



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№57 /501/

2023.04.06

Цаг үе, үйл явдал

## ДАРГА, ЗАХИРАГЧ НАРТАЙ ЦАХИМ ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАВ



ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлагч, удирдах газрын дарга, нэгтгэл, ангиудын захирагч нартай цаг үеийн асуудлаар цахим хуралдааныг зохион байгуулав.

Тэр бээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгт бэлтгэх, уг үзлэгийн удирдамжийн дагуу нэгдүгээр шатны ажлыг зохион байгуулах асуудлыг онцолж, үүрэг, чиглэл өгсөн юм.

Энэхүү түвшин тогтоох үзлэгийн гол зорилго нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх, дүрэмт хувцасны зөв хэрэглээг хэвшүүлэх, цаашид төрийн тусгай алба хаагчдад чиглэсэн ёс зүй, бие бялдрын сургалт бэлтгэлийг сайжруулах арга замыг оновчтой тодорхойлоход чиглэгдэж буй.

Иймд Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангиудын

түвшинд үзлэгийн нэгдүгээр шатыг энэ оны 04 дүгээр сард багтаан явуулах, ингэхдээ урьдчилан бэлтгэлийг сайтар хангах, үзлэгийн зорилго, ач холбогдлыг сайтар ойлгуулах, урьдчилсан хүргэсэн удирдамж, зааварчилгаа, албан даалгаврын хэрэгжилтийг нь бүрэн хангах, бие бүрэлдэхүүнтэй сурган зааварлах хичээл явуулах, үзлэгт цэргийн алба хаагчдыг бүрэн хамруулах, бодит үнэлгээ өгөх, дүнг ирэх сарын 05-ны дотор ирүүлэхийг үүрэг болголоо.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулах төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын "Залуу офицеруудын чуулган"-ыг угтсан ажлыг эрчимжүүлэх, командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагуудын түвшинд бодит үр дүнд хүрсэн ажлуудыг бүтээлчээр өрнүүлж, үр дүнг тооцох, Зэвсэгт хүчний шилдэг офицер шалгаруулах уралдааны эхний шатны шалгаруулалтыг амжилттай зохион байгуулах асуудлыг хөндсөн юм.

Тэрчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2022 оны 180 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд"-ийг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбар, цэргийн байгууллагад мөрдүүлж байгаа байдалд үзлэг явуулах тухай Батлан хамгаалахын сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгов.

Цахим хуралдааны төгсгөлд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр цаг үеийн тулгамдсан асуудлуудаар Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагуудын захирагч нарт мэдээлэл хийсний зэрэгцээ цаашдын үйл ажиллагаандаа анхаарвал зохих асуудлуудыг хөндөж, хэд хэдэн чиглэлээр үүрэг, чиглэл өглөө.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-1	-12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41	30

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,503	3,510
EUR	3,820	3,845
CNY	511	513.50
RUB	43.10	44.20
JPY	26.80	27
KRW	2.67	2.70

ЗУРХАЙ



2023.04.06 /ПҮРЭВ ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 15

**ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН  
ТУУЛАЙ САР  
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ  
МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.21-19.28

Барилдлага:

Хотол чуулган

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Сэрэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

## ОХУ-ЫН ЦЭРЭГ, АГААРЫН ЦЭРГИЙН АТТАШЕ ХОШУУЧ ГЕНЕРАЛ П.В.ПЕТРУНИНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат Оросын Холбооны Улсын Элчин сайдын яамны дэргэдэх Цэрэг, агаарын цэргийн атташегаар шинээр томилогдсон

хошууч генерал Павел Владимирович Петруниныг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хурандаа Т.Ганбат хошууч генерал П.В.Петруниныг томилогдсон явдалд

баяр хүргэж, хоёр улсын хооронд тогтоосон цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцсон байна.

**КОРОНАВИРУС  
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 684,452,707

Эдгэрсэн

Нийт: 657,376,904

Нас барсан

Нийт: 6,834,916

Цаг үе, үйл явдал

# "ТУСЛАХ АЖ АХУЙГАА ӨӨРСДИЙН БОЛОМЖДОО ТУЛГУУРЛАН ХӨГЖҮҮЛЖ БАЙНА"



Батлан хамгаалахын сайдын баримталж буй томоохон бодлогуудын нэг нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын туслах аж ахуйг хөгжүүлэх зорилт билээ.

Улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төвлөрсөн хангалтгүй нэгтгэл, анги, салбарууд өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан туслах аж ахуйгаа хөгжүүлэхэд нь салбар яамнаас нь дэмжинэ гэдгээ мэдэгдэж, энэ цаг үед Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт "Туслах үйл ажиллагаа эрхлэх заавар"-ыг шинэчлэн боловсруулж байгаа мэдээлэл байна.

Төсөл хэрэв сайдын тушаалаар батлагдаж бэлэн болбол туслах аж ахуйг зохистой хэмжээнд нь хэрхэн хөгжүүлэх талаар шинэчлэгдсэн баримт бичиг та бидний гар дээр ирнэ гэсэн үг.

Зэвсэгт хүчний Хуурай замын нэгтгэл, ангиудын хүрээнд туслах аж ахуй ямар түвшинд хөгжиж байгаа мэдээллийг Зэвсэгт хүчний 327 дугаар ангиар жишээлэн хүргэж байна.

Тус ангийнхан бие бүрэлдэхүүнийхээ мах, төмс хүнсний ногооны нийлүүлэлтийг өөрсдийн хүн, хүчний тусламжтайгаар дотооддоо зохион байгуулж, мал аж ахуй, газар тариаланг зохих хэмжээнд нь хослуулж яваа хамт олон.



Малын таван суурьтай, нэг нь бод, дөрөв нь богийн суурь. Дорнод аймгийн Сэргэлэн, Матад суманд мал аж ахуйгаа нутаглуулж, Хэрлэн сумын төвд усжуулалтын системийг нь шийдвэрлэсэн хоёр ч тариалангийн талбайд төмс хүнсний ногоогоо тариалж, өдөр тутамдаа хугацаа албаны дайчид цоо шинэ, эрүүл бүтээгдэхүүнийг хүнсэндээ хэрэглэдэг байна. Төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ өөрсдийн тариалалт болон худалдан авалт гэсэн хоёр хэлбэрээр хангаж, түүнийг хадгалах агуулахаа ч цэгцэлжээ. Тухайлбал, төмс хүнсний ногоо хадгалах зоорио эрүүл ахуйн стандартад нийцүүлэн төхөөрөмжилж, малын чулуун хороо, саравч барьж, худаг гаргах гээд мал аж ахуй, газар тариаланг дагасан бусад ажлыг сүүлийн жилүүдэд эрчимтэй гүйцэтгэж иржээ.

Мөн харилцагч буюу газар тариалан эрхлэгч томоохон аж ахуйн нэгжтэй хүн хүчний дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хамтран ажиллаж, өөрсдийн тариалдаггүй чацаргана, ногоон сонгиныг нийлүүлэлтээр авч, хоол хүнсэндээ хэрэглэдэг байна. Энэ жилээс саримсыг энэ зарчмаар хурааж, өвөл, хаврын цагт хугацаат цэргийн алба хаагчдынхаа дархлааг нэмэх зорилт тавьсан тухай тус ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч дэд хурандаа Х.Энхбаатар онцолж байсан юм. Мэдээж хавартаа мал ид төллөх үеэр малчдадаа хүн хүчний

туслалцаа үзүүлэх, намартаа өвс хадланг нь хураах болон боодол боодлоор нь тээвэрлэн хүргэх, өвөлдөө нүүлгэх гээд бүх талын дэмжлэг үзүүлдэг байна. Тэдний туслах аж ахуйгаас хамгийн онцлог ажил нь сүү, махны чиглэлийн үхрийн суурь ажээ. Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгаас шигшиж авсан үхэр сүргээ мах, сүүний чиглэлийн Симменталь, аргус болон Дорнодын улаан бух гэсэн үүлдэрээр үржүүлж эхлээд байгаа гэнэ.



Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхан туслах аж ахуйгаа зохистой хэмжээнд хөгжүүлэхээс гадна ногоон байгууламжийг ч ангийн байрлалдаа бусдад жишиг болгохуйцаар гүйцэтгэжээ.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудад хэрэгжиж байгаа "Эко-Ногоон хотхон" төслийн хүрээнд ангийн байрлалын ойр орчимд 1000 гаруй мод, суулгац тарьж, цэцэгжүүлэх ажлыг 2022 онд гүйцэтгэж, алба хаагчдынхаа ая тухтай, эрүүл орчинд ажиллах нөхцөлийг нь бүрдүүлсэн байна. Тэд энэ зун ногоон байгууламжаа цогц байдлаар улам төгөлдөржүүлэх зорилт тавьсан бөгөөд яг энэ цаг үед ангийнхаа мал аж ахуй, газар тариалан хариуцсан залуус нь хаврын тариалалтдаа бэлтгэж, шинэ төлөө аваад тун завгүй байгаа ажээ.

Ахмад Д.БОЛОР



# АНХДУГААР ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТААР...



Монгол Улсын Агаарын Уг анхдугаар зөвлөлдөх цэргийн командлал, Япон Улсын уулзалтаар хоёр орны Агаарын цэрэг Өөрийгөө хамгаалах Агаарын хүчин хоорондын хамтын ажиллагааны хоорондын анхдугаар зөвлөлдөх хүрээнд ойрын хугацаанд хэрэгжүүлэх уулзалт Улаанбаатар хотод амжилттай ажил, арга хэмжээнүүдийг зөвлөлдөн болж өндөрлөлөө. төлөвлөсөн юм.

# ОНОЛЫН ШАЛГАЛТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 189 дүгээр анги

2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Захирагчийн нэрэмжит нэгдүгээр үеийн төгсгөлийн онолын шалгалт"-ыг ангийн программ хангамжийн төвийн хөгжүүлсэн тестийн программыг ашиглан цахим хэлбэрээр зохион байгууллаа. Шалгалтыг цахим хэлбэрээр явуулснаар цаг хугацаа болоод эдийн засгийн хувьд хэмнэлттэй, шинэлэг байж чадсаныг холбогдох албаны хүмүүс онцолж байсан юм.

Хошууч Ц.ЦЭВЭГДОРЖ

# АЛБА ХААГЧ БҮРД ХҮРЧ АЖИЛЛАСАН СЭТГЭЛ ЗҮЙН СУРГАЛТ ЯВАГДЛАА



ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон "Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг"-ийнхэн 4 дүгээр сарын 05-ны өдөр Зэвсэгт хүчний 123 дугаар ангид ажиллалаа.

Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх зорилгоор сургалт хийж, харилцан ярилцаж, зөвлөгөө өгөв.

"Хамт олны сэтгэл зүй", "Харилцааны сэтгэл зүй", "EQ", "Цаг ашиглах үеийн сэтгэл зүй", "Зөрчил маргааны сэтгэл зүй" сэдвээр мэдээлэл өгөхийн зэрэгцээ сэтгэл зүйн сорил, тест, асуумжийг цэргийн алба хаагчдаас авч, тухайн хүний давуу болон сул тал, чадвар чадамжийг нь илрүүлж, цаашид өөрийгөө хэрхэн хөгжүүлэх талаар зөвлөгөө өгсөн юм.

Мөн бүлгийн болон ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулсан үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.

Ахмад Г.ОЮУН